



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 14 өдөр

Дугаар А/179

Мандалговь

ОХУ-аас Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан БНХАУ-руу байгалийн хий хоолой татах төсөлд шаардагдах баримт бичгийг бүрдүүлэх ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.21, 66.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. ОХУ-аас Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан БНХАУ руу байгалийн хий хоолой татах төсөлд шаардагдах баримт бичгийг бүрдүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)

Гишүүд: (Цагаандэлгэр сумын Засаг дарга)
(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Хууль тогтоомж, системчлэл, лавлагаа, хүний эрх, ГХУС асуудал хариуцсан мэргэжилтэн)

(Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Газрын удирдлагын хэлтсийн дарга)

(Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Эрчим хүч, харилцаа холбооны хяналтын улсын байцаагч)

(Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Газар, газрын хэвлий, түүний баялгийн ашиглалт, нөхөн сэргээлт, хөрсний доройтол цөлжилт, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хариуцсан мэргэжилтэн)

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Гадаад харилцааны ажилтан, Засаг даргын хэвлэлийн төлөөлөгч)

4822100419

Нарийн бичгийн дарга: (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Барилга, хот байгуулалт, дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн)

2. Засгийн газар, холбогдох яам, гүйцэтгэгч байгууллага, иргэдээс гарсан асуудал, судалгаа, мэдээллийг цаг хугацаанд нь шийдвэрлэн тухай бүр танилцуулахыг ажлын хэсэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ